

**2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 02-НЫ ӨДРИЙН ДҮҮРГИЙН УДИРДАХ
АЖИЛТНЫ ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР ЗАСАГ ДАРГААС
ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР**

Дүүргийн шуурхайн үүргийн биелэлтийг Агаар-12 фонтоор бичиж, 2023 оны 05 дугаар сарын 05-ны “Баасан” гарагийн 12:00 цагаас өмнө e-doc системээр албан бичгээр ирүүлж, Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (ERP Б.Одбаяр)-т файлаар ирүүлнэ үү. Хугацаа хэтэрсэн, албан бичгээр ирүүлээгүй тохиолдолд биелэлт ирүүлээгүйд тооцно.

Хугацаа заасан (үүрэг даалгавар 9, 10, 12) **үүрэг даалгаврын биелэлтийг энэ удаад ирүүлэх шаардлагагүйг анхаарна уу.**

№	Өгсөн үүрэг даалгавар	Хариуцах эзэн
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
1	Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны “Шил ажиллагааны хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг хангаж, ажлаа эрчимжүүлж ажиллах.	ТЗУХ ААНБ-ууд
2	Нийслэлийн Засаг даргын 2023 оны “Хууль, норм, дүрэм, стандартын хэрэгжилтийг хангуулах талаар авах зарим арга хэмжээний тухай” А/242 дугаар захирамжийн хэрэгжилтийг эрчимжүүлж, аж ахуйн нэгж байгууллагуудад барилгын чанар, стандартын хэрэгжилтийг хангуулж, хяналт тавьж ажиллах.	ТХҮХ
3	Нийслэлийн Засаг даргын 2023 оны “Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээ зохион байгуулах тухай” А/399 дүгээр захирамжийн хэрэгжилтийг хангаж, ажлаа эрчимжүүлэх.	МЭТ
4	“Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг шинэлэг хэлбэрээр зохион байгуулахаар бэлтгэл хангах.	НХХ, Боловсролын хэлтэс, ГБХЗХХ
5	Ерөнхий боловсролын сургуулийн орчинд хүүхдийг дээрэлхэж, эд зүйлсийг дээрэмдэх, хулгайлах, танхайрах зэрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд онцгой анхаарч ажлаа эрчимжүүлж, газар дээр нь тавих хяналтыг нэмэгдүүлэх.	Цагдаагийн хэлтэс, Боловсролын хэлтэс, ХЦС, 44, 207 дугаар цэцэрлэгүүд
6	Сургуулийн орчинд элс, хайрга, дайрга ачсан хүнд машин механизмын техникийн бүрэн бүтэн байдал болон замын хөдөлгөөний аюулгүй байдалд хяналт тавьж, хүүхдийг зам, тээврийн осолд өртөхөөс урьдчилан сэргийлж ажиллах.	Цагдаагийн хэлтэс, ЗЦТасаг
7	Авто замын засвар шинэчлэл, нөхөөс, тэмдэг, тэмдэглэгээг будах, явган хүний гарц, цагаан шугамыг угаах зэрэг ажлуудаа эрчимжүүлэх.	ТХҮХ
8	Айл өрхүүдийн нүхэн жорлонг ариутгах, халдваргүйжүүлэх, ашигтай бактер хийх ажлаа эрчимжүүлэх.	
ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
9	Улсын чанартай авто замын А0101 дугаартай Улаанбаатар-Чойр чиглэлийн замын дагуу дүүргийн нутаг дэвсгэрт байрлах 2 самбарыг шинэчлэх ажлыг 04 дүгээр сарын 10-ны дотор зохион байгуулах	ТХҮХ
10	Дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагууд орчныхоо 50 м хүртэлх талбайн өнгө үзэмжийг сэргээж, цэвэрлэгээг тогтмолжуулах, хайс хашааг угаах, хогны түүвэр цэвэрлэгээг 14 хоног тутамд хийх	ААНБ-ууд

11	Дүүргийн хэмжээнд ногоон байгууламжуудыг нэмэгдүүлэх, мод тарих, ургуулах, төгөлжүүлэх, арчлах, зүлэгжүүлэх, мөн харшлаас сэргийлж өнжмөл өвсний цэвэрлэгээ хийх ажлуудаа эрчимжүүлэх, 2023.05.12-ны өдөр зохион байгуулагдах мод тарих, ногоожуулах хөдөлгөөний бэлтгэлийг хангаж, ААНБ-ууд 50м ² - аас доошгүй талбайд ногоон байгууламжийг нэмэгдүүлэх чиглэлээр арга хэмжээ зохион байгуулж ажиллах.	ТХҮХ, Багахангай тохижилт, Багахангай гэрэлтүүлэг, ногоон байгууламж ОНӨААТҮГ-ууд, ААНБ-ууд
12	Орчны стандарт, аюулгүй байдлыг хангах ажлын хэсэг дүүргийн гудамж, зам талбайн эвдрэл гэмтэл, үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаатай танилцан, үзлэг шалгалтыг 04 дүгээр сарын 15-ны дотор зохион байгуулж, үүрэг чиглэл өгч ажиллах	ЗДО, ТХҮХ
13	Стратегийн команд штабын сургуулилттай холбоотой гамшгаас хамгаалах төлөвлөгөөг эцэслэн 2023.05.04-ний өдрийн дотор хүлээлгэн өгөх.	ААНБ-ууд
14	“Багахангай лиг 2023” дүүргийн аварга шалгаруулах гар бөмбөгийн тэмцээний хаалтын ажиллагааг зохион байгуулахтай холбогдсон бэлтгэл ажлыг сайтар хангаж ажиллах.	НХХ, БТСХ, Соёлын ордон
15	“Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд дүүрэгт зохион байгуулагдах сургалтын бэлтгэлийг хангах, оролцох албан хаагчдыг албан ёсоор чөлөөлж идэвхтэй хамрагдах.	ААНБ-ууд